



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 483

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 11,000,000.00 (арван нэгэн сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Автотээврийн үндэсний төвийн Ховд аймаг дахь Автотээврийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболор болон тогтоолд заасан байгууллагын даргад нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасгай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА




Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

• 132002251
22-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ... ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР-457 ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ ХОРИХ
АНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ,
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ХОВД АЙМАГ ДАХЬ АВТОТЭЭВРИЙН ТӨВД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Автомашины нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	
				Нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)
1	Приус-20, 21-02 ХОА (арал-nhw203243117)	2017	12,000,000.00	11,000,000.00	5
	Нийт дүн		12,000,000.00 (арван хоёр сая)	11,000,000.00 (арван нэгэн сая)	